



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 257

Улаанбаатар хот

**"ЭРДЭНЭС МОНГОЛ" ХХК-ИЙН НЭГДЛИЙН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТУХАЙ**

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.3, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэр дэх "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлагын "Эрдэнэс ҮТП" ХХК-ийг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн охин компани хэлбэрээр байгуулсугай.
2. "Эрдэнэс ҮТП" ХХК-ийн зохион байгуулалтын бүтэц, дүрмийг батлан мөрдүүлж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн)-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН